

БАТЛАВ.  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА *В. ГАНТУЯА* В. ГАНТУЯА

2020 оны 04-р сарын 01-н өдөр

УСЯ 0035 9018827

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН БАЯНТАЛ СУМЫН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

Огноо: 2020 оны 04-р сарын 01-ний өдөр

**“ЖИЖИГ ТЭРЭГ ХУДАЛДАН АВАХ /Суудлын автомашин/”  
БАРАА НИЙЛҮҮЛЭХ НИЙЛҮҮЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХАД  
ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: “ЖИЖИГ ТЭРЭГ ХУДАЛДАН АВАХ /Суудлын автомашин/”

Төслийн дугаар: ГСАБТСЗДТГ/20200101016/

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

**[Баянтал сумын Засаг даргын Тамгын газар** нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **“Жижиг тэрэг худалдан авах /Суудлын авто машин/”**–ыг нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 11 цаг 00 минутаас** өмнө битүүмжилсэн цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 11 цаг 30 минутад** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх. “Тооцно”

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Говьсүмбэр аймаг, Баянтал сум, 1-р баг, Сумын Засаг даргын  
Тамгын газрын байр, 3-р давхар, 17 тоот өрөө,  
Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн  
Утас: 94113190, 91045043,**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

  - (а) Үнийн санал;
  - (б) Үнийн боло нийлүүлэлтийн хуваарь;
  - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
  - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
  - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**

6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **ТШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>1.Сүүлийн <b>1 жил буюу 2019</b> оны санхүүгийн баталгаажуулсан тайлан</p> <p>2.Сүүлийн <b>1 жил буюу 2019</b> оны туршлагын мэдээлэл /ижил төрлийн суудлын авто машин нийлүүлж байсан гэрээ, барааг хүлээлгэн өгсөн комиссын актын хуулбарын хамт ирүүлнэ./</p> <p>3.Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулан ирүүлэх</p> <p>4.Бүх харилцагч банкны тодорхойлолт /өр зээлийн талаарх мэдээлэл/</p> <p>5.Татварын байгууллагын тодорхойлолт</p> <p>6.Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт</p> <p>7. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тодорхойлолт</p> <p>8.Сүүлийн <b>1 жил буюу 2019</b> оны борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнтэй дүйцэхүйц байх</p> <p>9.Бараа нийлүүлэлтийн хуваарийг компаний захирлаар баталгаажуулан ирүүлэх.</p> <p>10.Гэрээний ерөнхий болон тусгай нөхцлийг хүлээн зөвшөөрч байгаагаа албан мэдэгдлээр ирүүлнэ.</p> <p>11.Шалгарсан тохиолдолд “Техникийн тодорхойлолт”-д тусгасан шаардлагуудыг зөвшөөрч байгаа талаар албан мэдэгдэл ирүүлнэ.</p> <p>12.Харьяалагдах банк, татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас тодруулга авахад татгалзах зүйлгүй гэсэн албан бичиг ирүүлнэ.</p> <p>13.Нийлүүлэхээр санал болгож байгаа барааны техник үзүүлэлт болон фото зураг бүхий дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх.</p> <p>14.Нийлүүлэхээр санал болгож байгаа бараандаа 1 жилийн чанарын баталгаа өгөх талаар албан мэдэгдэл ирүүлэх</p> <p>15.Нийлүүлэхээр санал болгосон барааг захиалагчийн заасан цэгт туршилт хийж өгөх албан мэдэгдэл өгөх.</p> <p>16.ТШӨХ-д заасан аль нэг баримт бичгийг дутуу ирүүлсэн буюу ирүүлж буй материал нь тод гаргацтай байх ба засвартай болон харагдах боломжгүй бол ирүүлээгүйд тооцож тендерээс татгалзах үндэслэл болно. /Дээрх тодорхойлолтуудыг тендер зарлагдсанаас хойш холбогдох газруудаас гаргуулж эх хувиар ирүүлнэ./</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Тендерийн материалыг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрч цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 Мь, нэг файлын хэмжээ 15 Мь байна.</b></p> <p>Тендер хүлээн авах этгээд: <b>Баянтал сумын Засаг даргын Тамгын газар</b></p> <p>Огноо: <b>2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут</b></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>Говьсүмбэр аймаг, Баянтал сум, 1-р баг</b></p> <p>Давхар болон ерөөний дугаар: <b>Баянтал сумын Засаг даргын Тамгын газар, 3 давхар, 17 тоот</b></p> <p>Огноо: <b>2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр Цаг: 11 цаг 30 минут</b></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** “Жижиг тэрэг худалдан авах /Суудлын авто машин/”
2. **Бараа хүргэх газар:** Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын Тамгын газар
3. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
“Жижиг тэрэг худалдан авах”	Суудлын авто машин	1	ш	Баянтал сумын ЗДТГазар			

БАТЛАВ  
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
 ДАРГА  
 2020 оны 7 сарын 31 өдөр  
 УСД/0035 9018527

**“ЖИЖИГ ТЭРЭГ ХУДАЛДАН АВАХ/ суудлын автомашин/”  
 БАРААНЫ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

Сумын Засаг даргын Тамгын газарт “Жижиг тэрэг худалдан авах/ суудлын автомашин/” нь дор дурдсан техникийн тодорхойлолт, стандартад нийцсэн авто машин байна.

№	Нэр, төрөл, үзүүлэлт	Техникийн үзүүлэлт, давуу тал болох
1	Зориулалт	Суудлын
2	Марк	Toyota fielder
3	Үйлдвэрлэсэн улс Тоо ширхэг	Япон улс 1
4	Үйлдвэрлэсэн он	2010 оноос хойш
5	Ашиглагдсан байдал Техникийн байдал	<b>2020 онд Монгол улсад орж ирсэн</b>
6	километрийн заалт	Спидометрийн заалт бага байвал давуу тал болно
7	Жолооны хүрдний байрлал	Баруун
8	Шатахууны төрөл	Бензин
9	Хаалганы тоо	5
10	Суудлын тоо	5
11	Дугуйны хэмжээ	195 / 65R15
12	Автомашины өнгө	Мөнгөлөг саарал өнгөтэй байвал давуу тал болно.
<b>Динамик үзүүлэлт</b>		
13	Хөдөлгүүр	4 цилиндртэй
14	Хөдөлгүүрийн багтаамж	1496 м <sup>3</sup>
15	Хурдны хайрцаг	Автомат
<b>Нэмэлт тоноглол</b>		
16	Аккумулятор	Шинэ аккумулятортой байх
17	Хөгжим	Дэлгэцтэй хөгжим тоглуулагч
18	Запас дугуй	+
19	Галын хор	+
20	Эмийн сан, ослын гурвалжин	+
21	Резинен шалавч	+
22	Данхрат	+
23	Дугуйн дорцов	+

ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ БОЛОВСРУУЛСАН:

НИЙГМИЙН БОДЛОГО, ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН  
 МЭРГЭЖИЛТЭН  
 М.БОДЬГЭРЭЛ

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

**1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ**

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

4. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БҮЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |  |   |
|--|---|
| 1. Шалгах болон турших                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.   |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ. |
| 3. Оюуны өмчийн эрх                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.  |
| 4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.  |
| 5. Баталгаат засварын хугацаа                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>[1]</b> жил байна.   |
| 6. Гэрээнд өөрчлөлт оруулах                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.   |
| 7. Төлбөр  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ажлын <b>[5]</b> хоногийн дотор шуурхай хийнэ.   |
| 8. Бараа нийлүүлэх хуваарь                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.   |
| 9. Алданги оногдуулах                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.  |
| 10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.   |
| 11. Маргааныг шийдвэрлэх                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.  |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Нийлүүлэгдсэн авто машиныг Сумын ЗДТГазрын жолооч, бараа хүлээн авах ажлын хэсэг туршилт тохируулгыг хийж, техник үзүүлэлтүүдийг шалгаж хүлээн авна.  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | <p>2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:</p> <ol style="list-style-type: none"><li>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;</li><li>2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;</li><li>3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;</li><li>4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;</li><li>5) барааны гарал үүслийн гэрчилгээ.</li></ol> <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | <p>5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.</p> <p>Баталгаат засварын хугацаа 1 жил байна.</p>  |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | <p>7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:</p> <p><b>Нийлүүлэгдсэн авто машиныг комисст хүлээлгэн өгсөн акт, нэхэмжлэхийг үндэслэн ажлын 5 хоногийн хугацаанд 100 хувийн санхүүжилтыг олгоно.</b></p>  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)</b>                              | <p>9.1. Алданги оногдуулах хувь: <b>0,5</b></p> <p>Алдангийн нийт дүн: <b>гэрээний үнийн дүнгийн 10 хувь</b></p>   |

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>1</sup>

**БАТЛАВ.**

<b>ЗАХИАЛАГЧ</b>	<b>НИЙЛҮҮЛЭГЧ</b>
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>2</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>1</sup> Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

<sup>2</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*  
*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*  
*[Утас/факсын дугаар]*  
*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*